



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар Б/06

Сайншанд сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Шүүгч, шүүхийн ажилтанд буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.4, "Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 9.6, "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн ар гэрийн хөрөнгө мөнгөний гачигдалтай байдал зэргийг харгалзан шүүгчийн туслах Ц.Чинбаярт 333300 /гурван зуун гучин гурван мянга гурван зуу/ төгрөг, эвлэрүүлэн зуучлалын туслах ажилтан О.Батбямбад 333300 /гурван зуун гучин гурван мянга гурван зуу/ төгрөг, нийт 666600 /зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуу/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн 666600 /зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуу/ төгрөгийг тэтгэмж урамшлын зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч А.Сарантуяад зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БЭЭЖИН

000027